



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/238-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Т.Одсүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
МУЕП	Монгол Улсын ерөнхий прокурор
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.14 № 10А-2023/238 НАСТАВИЛ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ХУУЛЬ ЦААЗЫН ИТГЭМЖИТ
ЗӨВЛӨХ Э.УЛААНАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 91.8 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 6.3 хувиар, НДШ-ийн зардлыг 11.2 хувиар, тогтмол зардлыг 7.7 хувиар, дотоод албан томилолтын зардлыг 42.4 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 32.5 хувиар, бараа үйлчилгээний бусад зардлыг 67 хувиар, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 34.7 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 8.2 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 79.2 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд хангамж, бараа материалын зардалд 16,717.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 24,442.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 13,226.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

МУЕП-ын 2022 оны А/118 дугаар тушаалын дагуу батлагдсан цалингийн зардлын 3.0 хувь болох 7,561.9 мянган төгрөгийг МУЕПГ-ын "Ахмадын сангийн дансанд шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,552,535.00	13,116,225.00
34	УРЬДЧИЛГАА	14,240,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	14,240,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	11,312,535.00	13,116,225.00
35100	Түүхий эд материал	711,375.00	711,375.00
35110	Тусгай зориулалттай материал	711,375.00	711,375.00
35400	Хангамжийн материал	10,601,160.00	12,404,850.00
35410	Бичиг хэргийн материал	2,483,150.00	3,063,850.00
35420	Аж ахуйн материал	3,846,510.00	3,561,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	281,000.00
35450	Барилгын засварын материал	316,000.00	593,500.00
35470	Бусад хангамжийн материал	3,955,500.00	4,905,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	242,357,158.35	239,979,189.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	242,357,158.35	239,979,189.15
39200	Биет хөрөнгө	234,137,158.35	230,439,189.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,302,259.00	154,302,259.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,260,196.44)	(23,431,344.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,666,666.64)	(23,333,333.28)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	63,785,979.66	85,322,039.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,354,411.37)	(22,626,716.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,112,030.43	39,071,840.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,212,975.31)	(15,184,864.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,766,629.50	1,766,629.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(335,490.48)	(447,320.64)
39300	Биет бус хөрөнгө	8,220,000.00	9,540,000.00
39301	Програм хангамж	715,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(715,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	8,220,000.00	8,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	267,909,693.35	253,095,414.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	267,909,693.35	253,095,414.15
51	Засгийн газрын хувь оролцоо	267,909,693.35	253,095,414.15
51100	Засгийн газрын оруулсан капитал	72,082,380.00	72,082,380.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	72,082,380.00	72,082,380.00
51200	Хуримтлагдсан үр дүн	119,561,951.35	104,747,672.15
51210	Өмнөх үеийн үр дүн	86,793,956.60	119,561,951.35
51220	Тайлант үеийн үр дүн	32,767,994.75	(14,814,279.20)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76,265,362.00	76,265,362.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	267,909,693.35	253,095,414.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	395,484,588.00	380,137,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,978,188.00	22,165,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,978,188.00	22,165,950.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	21,999,188.00	22,165,950.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,979,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	370,506,400.00	357,971,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	370,506,400.00	357,971,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	370,506,400.00	357,971,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	362,175,927.18	385,618,395.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,175,927.18	385,618,395.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,296,575.18	354,936,614.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,972,682.00	236,258,200.94
210101	Үндсэн цалин	141,997,039.00	128,451,995.94
210102	Нэмэгдэл	67,105,643.00	83,595,010.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,870,000.00	12,950,000.00
	Урамшуулал	-	11,261,195.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,097,548.00	27,972,733.00
210201	Тэтгэврийн даатгал	19,577,962.00	19,924,521.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,185,818.00	2,344,064.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,708,335.00	1,834,929.00
210204	Ажилгүйдлийн даатгал	329,582.00	351,747.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,295,851.00	3,517,472.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,429,500.00	13,226,770.00
210301	Гэрэл, цахилгаан	1,503,097.00	2,272,013.00
210302	Түлш, халаалт	6,263,677.00	9,945,529.00
210303	Цэвэр, бохир ус	662,726.00	1,009,228.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,098,090.00	17,943,297.00
210401	Бичиг хэрэг	7,871,850.00	7,641,830.00
210402	Тээвэр, шатахуун	7,710,000.00	5,265,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,467,612.00	1,644,307.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,248,628.00	2,497,260.00
210408	Бараа материал акталсны зардал		870,900.00
2105	Нормативт зардал	-	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,724,700.00	4,016,500.00
210604	Урсгал засвар	23,724,700.00	4,016,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,991,000.00	1,669,500.00
210702	Дотоод албан томилолт	3,991,000.00	1,669,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,142,618.00	2,477,868.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,800,000.00	2,329,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	194,250.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,148.00	118,148.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00

210807	Газрын төлбөр	8,220.00	8,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,840,437.18	50,871,745.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,340,200.00	1,462,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	14,240,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,950,237.18	35,169,695.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,879,352.00	30,681,781.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	999,700.00	1,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	999,700.00	1,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,879,652.00	29,531,781.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,879,652.00	29,531,781.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	33,308,660.82	(5,480,945.84)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	540,666.07	9,333,333.36
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	540,666.07	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	9,333,333.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	32,767,994.75	(14,814,279.20)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	390,981,479.00	357,971,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	370,506,400.00	357,971,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	370,506,400.00	357,971,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	370,506,400.00	357,971,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	387,994,479.00	338,012,390.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,994,479.00	338,012,390.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,115,127.00	307,330,608.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,248,961.00	236,258,200.94
210101	Үндсэн цалин	142,273,318.00	131,194,889.18
210102	Нэмэгдэл	67,105,643.00	83,595,010.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,870,000.00	10,910,754.00
210104	Урамшуулал	-	10,557,547.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,097,548.00	27,972,733.00
210201	Тэтгэврийн даатгал	19,577,961.68	19,924,521.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,185,819.08	2,344,064.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,708,335.06	1,834,929.00
210204	Ажилгүйдлийн даатгал	329,582.02	351,747.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,295,850.16	3,517,472.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,429,500.00	13,226,770.00
210301	Гэрэл, цахилгаан	1,503,097.00	2,272,013.00
210302	Түлш, халаалт	6,263,677.00	9,945,529.00
210303	Цэвэр, бохир ус	662,726.00	1,009,228.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,405,500.00	16,717,987.00
210401	Бичиг хэрэг	7,387,500.00	7,046,730.00
210402	Тээвэр, шатахуун	7,710,000.00	5,265,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,467,612.00	1,644,307.00
210404	Ном, хэвлэл	409,000.00	-

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,631,388.00	2,737,950.00
2105	Нормативт зардал	-	1,450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,010,000.00	4,483,000.00
210604	Урсгал засвар	24,010,000.00	4,483,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,991,000.00	1,669,500.00
210702	Дотоод албан томилолт	3,991,000.00	1,669,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,142,618.00	2,653,368.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,800,000.00	2,505,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,148.00	118,148.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	8,220.00	8,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,790,000.00	2,899,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	2,899,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,790,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,879,352.00	30,681,781.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	40,000,000.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	40,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	999,700.00	1,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	999,700.00	1,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,879,652.00	29,531,781.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,879,652.00	29,531,781.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,987,000.00	19,959,110.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,987,000.00	19,959,110.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,987,000.00	19,959,110.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,987,000.00	19,959,110.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,987,000.00	19,959,110.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,987,000.00)	(19,959,110.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(20,000,000.00)	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000,000.00	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	86,793,956.60	235,141,698.60

2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	86,793,956.60	235,141,698.60
3	Тайлант үеийн үр дүн	-	-	32,767,994.75	32,767,994.75
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	119,561,951.35	267,909,693.35
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	119,561,951.35	267,909,693.35
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	119,561,951.35	267,909,693.35
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,814,279.20)	(14,814,279.20)
8	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	72,082,380.00	76,265,362.00	104,747,672.15	253,095,414.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлтийн зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	357,971,500.00	328,439,718.94	29,531,781.06	91.8
УРСГАЛ ЗАРДАЛ	357,971,500.00	328,439,718.94	29,531,781.06	91.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,211,500.00	327,289,718.94	28,921,781.06	91.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,062,400.00	236,258,200.94	15,804,199.06	93.7
Үндсэн цалин	139,688,700.00	131,194,889.18	8,493,810.82	93.9
Нэмэгдэл	87,736,700.00	83,595,010.00	4,141,690.00	95.3
Унаа хоолны хөнгөлөлт	16,536,000.00	10,910,754.00	5,625,246.00	66.0
Урамшуулал	8,101,000.00	10,557,547.76	(2,456,547.76)	130.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,507,700.00	27,972,733.00	3,534,967.00	88.8
Тэтгэврийн даатгал	21,649,300.00	19,924,521.00	1,724,779.00	92.0
Тэтгэмжийн даатгал	2,464,600.00	2,344,064.00	120,536.00	95.1
ҮОМШӨ-ний даатгал	1,971,700.00	1,834,929.00	136,771.00	93.1
Ажилгүйдлийн даатгал	492,900.00	351,747.00	141,153.00	71.4
Эрүүл мэндийн даатгал	4,929,200.00	3,517,472.00	1,411,728.00	71.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,329,400.00	13,226,770.00	1,102,630.00	92.3
Гэрэл, цахилгаан	1,674,500.00	2,272,013.00	(597,513.00)	135.7
Түлш, халаалт	10,903,400.00	9,945,529.00	957,871.00	91.2
Цэвэр, бохир ус	1,751,500.00	1,009,228.00	742,272.00	57.6
Хангамж, бараа материалын зардал	16,718,200.00	16,717,987.00	213.00	100.0
Бичиг хэрэг	5,519,400.00	7,046,730.00	(1,527,330.00)	127.7
Тээвэр, шатахуун	5,100,000.00	5,265,000.00	(165,000.00)	103.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,076,500.00	1,644,307.00	432,193.00	79.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	634,300.00	24,000.00	610,300.00	3.8

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,388,000.00	2,737,950.00	650,050.00	80.8
Нормативт зардал	1,500,000.00	1,450,000.00	50,000.00	96.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,450,000.00	50,000.00	96.7
Эд хогшил, урсгал засварын зардал	24,483,000.00	24,442,110.00	40,890.00	99.8
Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,999,300.00	700.00	100.0
Тавилга	10,000,000.00	9,959,810.00	40,190.00	99.6
Урсгал засвар	4,483,000.00	4,483,000.00	-	100.0
Томилолт, зочны зардал	2,900,000.00	1,669,500.00	1,230,500.00	57.6
Дотоод албан томилолт	2,900,000.00	1,669,500.00	1,230,500.00	57.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,928,500.00	2,653,368.00	1,275,132.00	67.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,780,000.00	2,505,000.00	1,275,000.00	66.3
Тээврийн хэрэгслийн татвар	118,200.00	118,148.00	52.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100.0
Газрын төлбөр	8,300.00	8,220.00	80.00	99.0
Бараа үйлчилгээний бусад зардал	8,782,300.00	2,899,050.00	5,883,250.00	33.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3,782,300.00	2,899,050.00	883,250.00	76.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	-	5,000,000.00	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,760,000.00	1,150,000.00	610,000.00	65.3
Бусад урсгал шилжүүлэг	1,760,000.00	1,150,000.00	610,000.00	65.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	1,150,000.00	610,000.00	65.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	357,971,500.00	328,439,718.94	29,531,781.06	91.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357,971,500.00	328,439,718.94	29,531,781.06	91.8
Улсын төсвөөс санхүүжих	357,971,500.00	328,439,718.94	29,531,781.06	91.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	13	11	2	84.6
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	4	3	1	75.0
Үйлчлэх ажилтан	8	7	1	87.5
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13	11	-	84.6
Ажлын албаны албан хаагч (АА)	2	1	1	50.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	7	1	87.5
Шүүгч, прокурор	3	3	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Прокурорын газар нь (цаашид Сайхан сум дахь сум дундын Прокурорын газар) “Хууль тогтоох байгууллагын бодлогын үзэл санааг тууштай дэмжиж, хяналтын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, зон олны эрх, эрх чөлөө, эд баялаг, түүхт уламжлалыг сахин хамгаалж, хууль тогтоомжийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх,
- Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах,
- Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх,
- Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих,
- Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2019 оны 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

МУЕП-ын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/125 дугаар тушаалаар УПЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,814.3 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж төлсөн зардал	14,240.0		(14,240.0)
Бараа материал	11,312.5	13,116.2	1,803.7
Үндсэн хөрөнгө	242,357.2	239,979.2	(2,378.0)
Нийт хөрөнгө	267,909.7	253,095.4	(14,814.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	267,909.7	253,095.4	(14,814.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	267,909.7	253,095.4	(14,814.3)

Өмнөх онд урьдчилж гарсан зардлаар тайлагнагдсан 14,240.0 мянган төгрөгийн гэрээт сургалтыг тайлант онд гүйцэтгэж, гэрээг дүгнэснээр уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 325,002.8 мянган төгрөг болж 22,100.8 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 19,959.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан,
- УЕПГ-аас 20,845.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр шилжин ирсэн,
- Ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой санхүүгийн программыг дахин үнэлж 1,320.0 мянган төгрөгөөр орлого авсан,
- ТӨБЗГ-ын 2022 оны 262 дугаар тогтоол, МУЕП-ын 2022 оны А/61 дүгээр тушаалын дагуу цаашид ашиглах боломжгүй болсон 9,309.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан данснаас хассан,
- МУЕП-ын 2022 оны А/79 дугаар тушаалаар Баянгол дүүргийн Прокурорын газарт 10,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг баланс хооронд шилжүүлсэн,
- Дахин үнэлгээний зөрүүтэй холбоотой 715.0 мянган төгрөгийн хөрөнгийн бууралт хийгдсэн гэх зэрэг.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 253,095.4 мянган төгрөг болж 14,814.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 430,271.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа ажил үйлчилгээний зардлыг 110,825.5 мянган төгрөгөөр бууруулж 319,445.5 мянган төгрөгөөр баталсан байна. */цалингийн зардлыг 3,809.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 28.9 мянган төгрөгөөр, нэмэгдүүлж, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4,377.0 мянган төгрөгөөр, хангамжийн зардлыг 13,206.5 мянган төгрөгөөр, нормын хувцасны зардлыг 2,835.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 75,732.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 2,022.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,843.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 10,022.3 мянган төгрөг/*

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт 5,10,11 дүгээр саруудад өөрчлөлт оруулж нийт 38,526.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсөвт зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- *Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,686.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 400.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 571.5 мянган төгрөгөөр бууруулж,*
- *Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 6,300.0 мянган төгрөгөөр*
- *Нормын хувцасны зардлыг 1,500.0 мянган төгрөгөөр*
- *Хангамж, эд хогшил, урсгал засварын зардлыг 23,841.2 мянган төгрөгөөр,*

- Бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 8,782.3 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 1,760.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 357,971.5 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 357,971.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 328,439.7 мянган төгрөг буюу 91.8 хувьтай байгаа бараа үйлчилгээний зардлын төсвийг 28,921.8 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 610.0 мянган төгрөгөөр хэмнэж улсын төсөвт 29,531.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр,	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	70703- Прокурорын хяналт	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	353,711.5	324,794.7	28,916.8	91.8
2		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,760.0	1,150.0	610.0	65.3
3		82315-Байцаан шийтгэх ажиллагаа	2,500.0	2,495.0	5.0	99.8
Бүгд дүн			357,971.5	328,439.7	29,531.8	91.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130906401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн

үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмжүүдийг өглөө.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/70 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 362,175.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,621.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор УЕПГ-ын 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 2/1579 дүгээр “Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай” албан бичгийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг тодорхой хэмжээгээр хэмнэсэн,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч үр ашиггүй зардал гаргахгүй ажилласан,
- Худалдан авах бараа материалын төсвийг хийж, ерөнхий прокуророор хянуулан шаардлагатай, зайлшгүй хэрэгцээт материалыг худалдаж авч зарцуулан, төсвийг зохистой удирдаж өр төлбөргүй тайлагнагдсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын мэдээлбэл зохих 117 мэдээллээс 99 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 18 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын мэдээлэл-2 удаа,
- Бусад мэдээлэл 17 удаа,

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж хүргүүлэх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	61,452.8	2	61,452.8	2
Нийт дүн	2	61,452.8	2	61,452.8	2

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны

төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Тайлант жилийн төсөвт тусгагдаж, батлагдаагүй байхад МУЕП-ын 2022 оны А/118 дугаар тушаалын дагуу батлагдсан цалингийн зардлын 3.0 хувь болох 7,561.9 мянган төгрөгийг УЕПГ-ын ахмадын сангийн дансанд шилжүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Төсвийн жилийн эцэст буюу 11 дүгээр сард төсвийн зохицуулалтаар зөөлөн эдлэл нормын хувцасны зардалд **1,450.0** мянган төгрөгийн санхүүжилт олгож шинээр томилогдсон прокурорын дүрэмт хувцасны хангалтыг орон нутгийн нэгжээс зохион байгуулсан нь УЕП-ын 2020 оны А/05 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Прокурорыг дүрэмт хувцас, түүний чимэг, хэрэглэлээр хангах журам”-ын 3.1-т “Прокурорын дүрэмт хувцас, түүний чимэг хэрэглэлээр хангах ажлыг Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газар хариуцан зохион байгуулна.” 3.8-т “Тамгын хэлтсийн дарга нь прокурорын дүрэмт хувцас, түүний чимэг, хэрэглэлийг прокурорт хүлээлгэн өгч, дүрэмт хувцасны карт хөтлөн хяналт тавьж ажиллана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт дансны бичилт буруу хийсэн **114,022.4** мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг залруулав. Үүнд:

- Илүү олгосон цалинг ажилчдаас суутган тайлагнахдаа цалингийн зардлыг бууруулалгүйгээр бусад орлогоор бүртгэсэн 697.7 мянган төгрөг,
- Урсгал зардлаас бэлтгэсэн хөрөнгийн зардлын дансны бичилт буруу хийж үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн худалдан авсан дүнтэй зөрсөн 19,959.1 мянган төгрөг,
- Цалингийн урьдчилгааны тооцоог цалингийн өглөг дансаар дамжуулсан 91,696.1 мянган төгрөг,
- Дотоод албан томилолтын тооцоог шууд зардлаар тайлагнасан 1,669.5 мянган төгрөг.

Аудитаар 4,954.1 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илрүүлж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.1. Илрүүлэлт: Албан хаагчдын эрүүл мэнд, дархлаа дэмжих зорилгоор бараа ажил үйлчилгээний зардлын батлагдсан төсвөөс 1,363.1 мянган төгрөгийн эм бүхий эмийн сан бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь ".....болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Урсгал засварын төсөв, гүйцэтгэлийн тайлан, машин засварын техникийн комиссын акт, ӨХБЗ-ийн хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар автомашины гражийн засварт 1,129.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэлд 2,462.0 мянган төгрөгийн зэрэг нийт 3,591.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

3. Хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Тайлант жилд үндсэн хөрөнгийн бүртгэлд шинээр орлогод авсан 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын жилийг үндэслэлгүй тогтоож, бүртгэсэн байна.

Энэ нь төсвийн хөрөнгийг үнэгүйдүүлэх эрсдэлийг үүсгэж байгаа бөгөөд МУЕП-ын 2021 оны А/179 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.2.1-т заасан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа"-г зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацааг үнэн зөв тогтоож, бүртгэх, хөрөнгийн ашиглалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дансны бичилт буруу хийсэн ажил гүйлгээний алдааг залруулав	4	114.022.4			4	114.022.4	4	114.022.4				
Дүн	4	114,022.4			4	114,022.4	4	114,022.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулсан	1	1,363.1					1	1,363.1				
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн	1	3,591.0					1	3,591.0				
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг буруу тогтоосон	1						1					
Дүн	3	4,954.1					3	4,954.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	18						18	
Дүн	18						18	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	18						18	